# ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ ЦАХИМ ШИЛЖИЛТИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ Т.ПҮРЭВСҮРЭНГИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

| Д/Д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Гүйцэтгэлийн түвшин | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Төрийн байгууллагын үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэх, бизнес процессын дахин инженерчлэл хийх** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1.1. Яамны төлөвлөгөөний 36.** Нийтийн мэдээллийн дэд бүтцийн өнөөгийн нөхцөл байдлын судалгаа хийх, санал, зөвлөмж боловсруулна. | Судалгааны тоо, зөвлөмжийн тоо | - | 2 | Нийтийн мэдээллийн дэд бүтцийн өнөөгийн нөхцөл байдлын судалгаа хийх, санал, зөвлөмж боловсруулах ажлын даалгаврыг боловсруулан үнэлгээний хороонд хүргүүлсэн. Тус ажлыг СБТГ хариуцан хэрэгжүүлж байна. | 2025.05.01 - 2025.12.31 | - |
| 2. | **Арга хэмжээ 1.2. Яамны төлөвлөгөөний 54.** Кирил болон үндэсний бичгийн хооронд харилцан хөрвүүлэг хийх, зөв бичгийн | Нэвтрүүлсэн системийн тоо | - | 1 | Хэлний бодлогын үндэсний зөвлөлөөс баталгаажуулсан “Дуаллайн” ХХК-ийн боловсруулсан “Алдаа шалгагч, бичиг | 2025.03.12 - 2025.12.31 | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дүрмийн алдаа хянах программ нэвтрүүлнэ. | | | | хөрвүүлэгч” программ нь төрийн үйл ажиллагаанд нэвтрүүлэн ашиглахад аюулгүй байдлын хувьд эрсдэлтэй талаар ЗГХЭГ-ын 2025.04.17-ны өдрийн ХЭГ/1043 дугаар албан бичиг (Тагнуулын ерөнхий газрын даргын 2025.04.01-ний өдрийн ЗГХЭГ-ын тэргүүн дэд даргад хүргүүлсэн ТЕГ01/128 дугаар албан бичиг)-ээр ирсэн тул эрсдлийг бууруулахад чиглэсэн агуулга бүхий Ажлын даалгаврын төслийг боловсруулан хамтран батлахаар Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын албанд Төрийн нарийн бичгийн даргын 2025.04.28-ны өдрийн 02/975 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | | |

| Зорилт 2. Цахим засаглалыг хөгжүүлэх, нэвтрүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | **Арга хэмжээ 2.1. Яамны төлөвлөгөөний 47.** "Дижитал аймаг - Дижитал хот" зөвлөмжийн хэрэгжилтийг зохион байгуулна. | Зөвлөмж хэрэгжүүлсэн аймаг, дүүргийн тоо | 2 | 8 | "Цахим аймаг–Дижитал хот" зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлэх ажлын хэсгийн тушаалыг ЦХИХХС-ын 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/07 дугаар тушаалаар батлуулсан бөгөөд тус ажлын хэсэг 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдөр хуралдаж ажлын хэсгийн төлөвлөгөөг баталсан. 2025 онд 7 аймагт "Цахим аймаг–Дижитал хот" зөвлөмжийн хэрэгжилтийг зохион байгуулахаар худалдан авах ажиллагааны ажлын даалгаврыг боловсруулан 2025.03.31-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, Төрийн худалдан авах ажиллагааны цахим | 2025.03.12 - 2025.12.31 | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | системээр 2025.05.08-ны өдөр нээлттэй тендер зарлаж, 2025.05.29-ны өдөр тендерийг нээсэн. Тендерийг үнэлэх үйл ажиллагаа явагдаж байна. | | |
| 4. | **Арга хэмжээ 2.2. Яамны төлөвлөгөөний 68.** Олон нийтийн байгууллагуудын засаглалыг дэмжих нээлттэй платформ хөгжүүлнэ. | Нэвтрүүлсэн системийн тоо | - | 1 | Ажлын даалгаврыг боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргаар 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр батлуулсан бөгөөд 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/93 тушаалаар худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороо байгуулагдсан. Үйлчилгээг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлан 2025.05.28-ны өдөр нээсэн. Тендерт оролцогчдыг хянан, үнэлэх ажиллагаа явагдаж байна. | 2025.03.12 - 2025.12.31 | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 3. Төрийн цахим үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, нэгдсэн төлөвлөлт хийх, мэргэжил, арга зүй, технологийн шийдэл, удирдлагаар хангах** | | | | | | | |
| 5. | **Арга хэмжээ 3.1. Яамны төлөвлөгөөний 51.** Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шаардлагатай системүүдийг хувийн хэвшилд шилжүүлэх ажлыг зохион байгуулна. | Системийн тоо | - | 2 | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шаардлагатай системүүдийг хувийн хэвшилд шилжүүлэх ажлыг зохион байгуулахаар судалж байна. Тайлант хугацаа нь болоогүй байгаа. | 2025.07.01 - 2025.12.31 | - |
| **Зорилт 4. Төрийн байгууллагуудын мэдээллийн сан, мэдээллийн систем, нээлттэй өгөгдлийг уялдуулах, нийтийн түлхүүрийн дэд бүтцийн тогтолцоо, нийтийн мэдээллийн дэд бүтцийг хөгжүүлэх, зохион байгуулах, зохицуулах** | | | | | | | |
| 6. | **Арга хэмжээ 4.1. Яамны төлөвлөгөөний 60.** Сэлгэн ажиллах /high availability/ дата төвийн тоног төхөөрөмжийн нөөцийг бий болгоно. | Хэрэгжилтийн хувь | 0 | 100 | Үндэсний дата төв УТҮГ-аас Сэлгэн ажиллах нөөц төвд шаардлагатай сервер, сүлжээ, хадгалах төхөөрөмж зэрэг 10 төрлийн 128 ширхэг техник хэрэгслийн тодорхойлолтыг боловсруулсан ирүүлсний дагуу “Сэлгэн ажиллах дата төвийн нөөцийн тоног төхөөрөмж нийлүүлэх” ЦХИХХЯ/2025010213 5 дугаар бүхий худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна. | 2025.03.12 - 2025.12.31 | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7. | **Арга хэмжээ 4.2.** Үндэсний дата төвийн үндсэн болон нөөц төвийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ. | Хүчин чадал, хувиар | 50 | 100 | Үндэсний дата төв УТҮГ-аас дата төвийн үндсэн болон нөөц төвийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд шаардлагатай дэд бүтцийн тоног төхөөрөмж, программ хангамж, мэдээллийн аюулгүй байдлын 20 төрлийн 102 ширхэг техник хэрэгслийн техникийн тодорхойлолтыг боловсруулсан ирүүлсний дагуу “Ухаалаг засаг 2 төсөл”-ийн хүрээнд “Үндэсний дата төвийн үндсэн болон нөөц төвийн хүчин чадлыг нэмэгдүүлэх" 2.2.1.1 дугаартай төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, үнэлэх ажил хийгдэж байна. | 2025.03.12 - 2025.12.31 | 50% |
| **Зорилт 5. Цахим орчинд харилцаа холбоо, мэдээллийн технологийн зөв зохистой хэрэглээний соёлыг нэвтрүүлэх, бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэн, тоон хуваагдлыг бууруулах, иргэдийн мэдээлэл авах хүртээмжийг нэмэгдүүлэх** | | | | | | | |
| 8. | **Арга хэмжээ 5.1. Яамны төлөвлөгөөний 73.** | Батлагдсан ажлын даалгаврын тоо | - | 1 | Ажлын даалгаврыг боловсруулан 2025.03.31-ны өдөр | 2025.03.12 - 2025.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сонсголын бэрхшээлтэй, харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан хиймэл оюуны хөрвүүлэгч систем нэвтрүүлнэ. | | | | Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. | | |
| 9. | | Системийн тоо | - | 0 | Төрийн нарийн бичгийн даргын 2025.04.30-ны өдрийн А/124 дугаар тушаалаар үнэлгээний хороо байгуулагдсан. Тендерийг 2025.06.02-ны өдөр нээж, хянан үнэлэх ажил хийгдэж байна. | 2025.05.01 - 2025.12.31 | 70% |
| **ХОЁР. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 10. | Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журамд заасан хугацаанд боловсруулж батлуулах, тайлагнана. | Батлагдсан төлөвлөгөөний тоо | - | 1 | Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журамд заасан хугацаанд боловсруулж батлуулан, тайлагнасан. | 2025.03.12 - 2025.12.31 | 100% |
| | | Тайлангийн тоо | - | 1 | | 2025.03.12 - 2025.12.31 | 100% |
| 11. | Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, холбогдох журамд заасны дагуу цохогдсон өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэнэ | Шийдвэрлэсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн тоо | 6 | Хэрэгжилтээр | 2025.03.12-оос хойш хариуцсан ажлын хүрээнд өргөдөл, гомдол ирээгүй болно. | 2025.03.12 - 2025.12.31 | 100% |
| 12. | Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг | ХАСХОМ бөглөх болон хуулийн хэрэгжилтийг | 5 | 6 | ХАСХОМ-ийг хуулийн хуулийн хугацаанд илгээж хэрэгжилтийг | 2025.03.12 - 2025.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ. | хангаж, ажилласан баримтын тоо | | | ханган ажилласан болно. | | |
| 13. | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг заасан хугацаанд нь чанартай гүйцэтгэх, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлнэ. | Өгсөн үүрэг даалгаврын тоо | - | Хэрэгжилтээр | 1. ЦШБЗГ-ын хариуцсан 97 ажлын “Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт”-ийн 2025 оны 1 дүгээр улирлын тайланг ТЗУГ-т хүргүүлсэн.<br>2. ЭЗХЯ-наас "МУ-ын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө"-ний төсөлд санал авахаар ирүүлсэний дагуу Монгол Улсын Хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөлд нэмж тусгах 6 ажлын төслийн тайлбар, хэрэгцээ шаардлагыг тодорхойлон СБТГ-т хүргүүлсэн.<br>3. Монгол Улсыг 2025-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд оруулах 30 | 01 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тэрбум, түүнээс дээш өртөгтэй төсөл, ажил, арга хэмжээний төслийн саналд “Хүннү хотын чөлөөт бүсэд дата төв байгуулах” төслийг холбогдох загвар, маягтын дагуу боловсруулан СБТГ-т хүргүүлсэн.<br>4. ЦХИХХСайдын 2025 оны А/59 дүгээр тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн тайланг ТЗУГ-т хүргүүлсэн. | | |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.** Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэлд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны төсвийн | Хүргүүлсэн баримт бичгийн тоо | - | 1 | Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэлд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны төсвийн ерөнхийлөн захирагчийн цахим шилжилтийн төсвийн саналыг боловсруулан СХОХ-т хүргүүлсэн. | 2025.05.19<br>2025.05.20 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ерөнхийлөн захирагчийн цахим шилжилтийн төсвийн саналыг боловсруулж, СХОХ-т хүргүүлнэ. | | | | | | |
| 2. | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2.** Монгол Улсад албан ёсоор 5G сүлжээ ашиглах тусгай зөвшөөрөл олгох ёслолын ажиллагааг зохион байгуулна. | Үйл ажиллагаа ны тоо | - | 1 | Монгол Улсад албан ёсоор 5G сүлжээ ашиглах тусгай зөвшөөрөл олгох ёслолын ажиллагааг 2025. оны 05 дугаар сарын 16-нд Монгол шуудан ХК-ийн дугуй зааланд зохион байгуулсан. Зохион байгуулалтын хүрээнд хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, заалны зураг гаргаж, тохижилт хийх, арга хэмжээнд оролцогчдыг зохион байгуулалтаар хангах, нээлтийн арга хэмжээг хөтөлбөрийн дагуу зохион байгуулах ажлууд хийгдсэн. | 2025.05.13 2025.05.16 | 100% |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | **Арга хэмжээ 2.** Эрхэлсэн ажлын чиглэлээр дотоодод зохион байгуулагдах сургалт, хурал, | Дотоодод зохион байгуулагдах сургалт, хурал, семинарт оролцсон тоо | - | 1 | НҮБ-ын Хүүхдийн Сангийн дэмжлэгтэйгээр 2025 оны 04 дүгээр сарын 10, 11-ний өдрүүдэд вакум хэлбэрээр зохион байгуулагдсан Монгол Улсын “Цахим эрүүл мэнд”-ийн цогц арга хэмжээний төлөвлөгөө (2025-2028)-г хэлэлцэх уулзалт, хэлэлцүүлэгт оролцсон. Тус уулзалтаар Эрүүл мэндийн тухай хуулийн 8.10 дахь заалтын хүрээнд боловсруулсан журам | 2025.03.12-2025.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | семинарт оролцох | | | | болон цахим эрүүл мэндийн цогц арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулан хэлэлцүүлсэн. | | |

**ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:**

| | | |
|---|---|---|
| НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ | Т.ПҮРЭВСҮРЭН / .......................... / | ......... ......... ......... |
| *( Албан тушаал )* | *( Нэр, гарын үсэг )* | *( Огноо )* |

----oOo----